

ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Хууль зүй,
дотоод хэргийн сайдын
тушаалын төслийн талаар

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсэгт “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”, 21.10 дахь хэсэгт “Энэ хуулийн ... 7.1.7, 7.1.8, 7.1.9-д заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалалтад авах гэрч, хохирогч, хамтран хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хэлбэрээс хамаарч гэрээнд холбогдох эрх, үүрэг, хариуцлагыг тусгана.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.3.6-д “Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгож, гэрч, хохирогчийн хамгааллын цогц механизмыг бүрдүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль”-д 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-ыг боловсрууллаа.

Журмын төсөлд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, баривчлах төв, хорих ангийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, салбар нэгжүүдэд хоригдож байгаа хоригдол, хоригдогч /цаашид “Хамгаалуулагч” гэх/-д Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх харилцааг зохицуулах, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.7-7.1.9 дахь хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалалтад авах гэрч, хохирогч, хамтран хэрэгжүүлэх байгууллагатай гэрээ байгуулах болон шаардлагатай тохиолдолд хамгаалуулагчийн байршлыг өөрчлөх харилцааг зохицуулсан.

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.7-7.1.9 дахь хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг, хамгаалалтын арга хэмжээний явцад хамгаалалтын тусгай алба, эрх бүхий албан тушаалтны хийж гүйцэтгэх ажлын чиг үүргийг тусгасан.

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.7-7.1.9 дахь хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээг авахдаа хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэгч байгууллага болон хамгаалуулагчийн эрх, үүрэг, болон хориглох үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг тусгасан.

- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.10 дахь хэсэгт заасны дагуу тушаалын хавсралтаар “Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллагатай ажиллах гэрээ”, “Гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”, “Насанд хүрээгүй гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”-ний загваруудыг баталсан хавсралттай байх бөгөөд гэрээнд нийтлэг үндэслэл, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, хамтран хэрэгжүүлэгч байгууллага, хамгаалуулагчийн үүрэг, хамгаалуулагчийн эрх, үүрэг, хориглох зүйл, гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох, маргаан шийдвэрлэх, зэрэг асуудлыг зохицуулахаар тусгалаа.

Журмын төслийг ХЗДХЯ, ЦЕГ-ын цахим сайтад байршуулан олон нийт, Улсын ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөхий газраас албан бичгээр санал авч, ирүүлсэн саналыг тусгасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт хангагдах бөгөөд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг бүрэн хангах боломж бүрдэнэ.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ**

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-ыг нэгдүгээр, “Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллагатай ажиллах гэрээ”-ний загварыг хоёрдугаар, “Гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”-ний загварыг гуравдугаар, “Насанд хүрээгүй гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”-ний загварын дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Журам, гэрээний загваруудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газрын дарга /тэргүүн комиссар З.Дашдаваа/-д зөвлөж, Тагнуулын ерөнхий газрын дарга /хурандаа П.Одонбаатар/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Болд/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /хурандаа Д.Загджав/ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-д даалгасугай.

Х.НЯМБААТАР

*Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт*

ЦАГДАН ХОРИГДОЖ БАЙГАА БОЛОН ХОРИХ ЯЛ ЭДЭЛЖ БАЙГАА ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, цагдан хорих байр, хорих ангийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, салбар нэгжүүд /цаашид “Хорих байгууллага” гэх/-д хоригдож байгаа хоригдол, хоригдогч /цаашид “Хамгаалуулагч” гэх/-д Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмын 1.1 дэх хэсэгт заасан хорих байгууллагад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актыг баримтална.

1.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан байгууллагын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай алба /цаашид “Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага” гэх/, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” гэх/, цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд “Хамгаалалтын арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх байгууллагатай ажиллах гэрээ”, “Гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”, “Насанд хүрээгүй гэрч, хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ”-ний аль тохирохыг байгуулна.

1.4.Хамгаалалтын арга хэмжээг гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эрүүгийн цагдаагийн нэгж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

1.5.Шаардлагатай тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын санал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 195 дугаар зүйлийн 195.4 дэх хэсгийг үндэслэн хамгаалуулагчийн байршлыг өөрчилж болно.

1.6.Хамтран хэрэгжүүлэх байгууллага нь хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын хамгаалалтын үйл ажиллагаанд саад учруулахгүй, бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн 230.5 дахь хэсэгт заасан бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Хоёр.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

2.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дор дурсан эрх эдэлнэ:

2.1.1.хамгаалалтын арга хэмжээний хэлбэр, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага эрсдэлийн түвшингээс хамаарч хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зохион байгуулалтын арга хэмжээ авах саналыг тухай бүр хамтран хэрэгжүүлэх байгууллагад гаргаж даруй шийдвэрлүүлэх;

2.1.2.хамгаалуулагчийн хувийн хэрэг, ял эдлэлийн байдалтай холбоотой бусад баримт бичиг, мэдээллийг хамтран хэрэгжүүлэх байгууллагаас гаргуулан авч танилцах, шаардлагатай баримт бичгийг хуулбарлан авах;

2.1.3.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хяналт тавих зорилгоор түүний амьдралын бүсэд тусгай техник, хэрэгсэл байршуулан ашиглах;

2.1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтад заасны дагуу сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.1.5.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад, прокурорын зөвшөөрөлгүй албан тушаалтанг хамгаалуулагчийн өрөө, байранд нэвтрүүлэхгүй байх, хамтран хэрэгжүүлэх байгууллагад шаардлага тавих;

2.1.6.хамгаалалтын арга хэмжээнд хамтран хэрэгжүүлэх байгууллагаас ажиллах нэр заагдсан алба хаагчаас нууцлал аюулгүй байдлын баталгаа гаргуулж биелэлтэд хяналт тавих;

2.1.7.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах.

2.2.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дор дурсан үүрэг хүлээнэ:

2.2.1.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай шийдвэрийг хүлээж авсан даруйд хамтран ажиллах байгууллага, хамгаалуулагчтай гэрээ байгуулж, хамгаалалтыг зохион явуулах;

2.2.2.хамгаалуулагч өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгч болон бусад хүнтэй уулзах, шүүх хуралд оролцох, мөрдөн шалгах тодорхой ажиллагаанд оролцох, аливаа хөдөлгөөн үйлдэх үед хүч нэмэгдүүлсэн хамгаалалтын арга хэмжээг дангаар болон хамтран зохион байгуулж аюулгүй байдлыг хангах;

2.2.3.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага нь хамтран хэрэгжүүлэгч байгууллагын мөрдөж буй хууль тогтоомжийг зөрчихгүй байх;

2.2.4.хамгаалалтад ажиллаж байгаа алба хаагч хамгаалуулагч, хамгаалалтын бүсийг дур мэдэн орхиж явахгүй байх;

2.2.5.тусгай техник, хэрэгслийг зориулалтын бусаар хэрэглэхгүй байх;

2.2.6.хувийн харилцаа тогтоохгүй байх.

Гурав.Хамтран хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

3.1.Хамтран хэрэгжүүлэх байгууллага нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний үйл ажиллагаанд оролцохдоо дор дурдсан эрх эдэлнэ:

3.1.1.хорих ангийн болон хорих байрны дотоод журмыг тус тус мөрдлөг болгон ажиллах;

3.1.2.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай шийдвэртэй танилцах, хуулбарлан авах.

3.2.Хамтран хэрэгжүүлэх байгууллага нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээний үйл ажиллагаанд оролцохдоо дор дурдсан үүрэг хүлээнэ:

3.2.1.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл зүйд аюул заналхийлэл учруулж болзошгүй талаар мэдээ, мэдээлэл авагдсан тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, алба хаагчид даруй мэдэгдэх;

3.2.2.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын алба хаагчдад үндэслэлтэй халхавч бүрдүүлэн, албаны нууцлал аюулгүй байдлыг ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.3.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагаас хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой гаргасан саналыг холбогдох журмын дагуу даруй шийдвэрлэж, хариу өгөх, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

3.2.4.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамгаалуулагчийг тусгаарлах, хамгаалалтын бүс тогтоох талаар дор дурдсан ажлыг зохион байгуулна:

3.2.4.1.хамгаалуулагчийн хорих өрөө, байр, хөдөлгөөн үйлдэх цэгүүд /нийтийн ариун цэврийн өрөө, халуун усны өрөө, наралгааны хэсэг, хоригдлын гал тогооны хэсэг, эмчилгээний өрөө/-нд тогтоосон хамгаалалтын бүсэд бусад хоригдол, хоригдогч, алба хаагч, иргэдийг нэвтрүүлэхгүй байх;

3.2.4.2.хамгаалалтын бүс нь хамгаалуулагч, бусад хоригдол, хоригдогч, алба хаагчид, иргэдийн хараалах бүсээс далдлагдсан байх ба дуу чимээ, яриа өгүүлэл гадагш, дотогш нэвтрэхгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.4.3.хамгаалуулагчийн байрлах өрөө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 209 дүгээр зүйлд заасны дагуу олон улсын стандарт шаардлагыг хангасан байхаас гадна дуу, чимээ тусгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх.

3.2.5.хорих анги, цагдан хорих байранд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах нөхцөл байдлыг харгалзан ажиллана:

3.2.5.1.хамгаалуулагчийг бусад хоригдол, хоригдогч, алба хаагч, иргэдээс тусгаарлах;

3.2.5.2.шаардлагатай гэж үзвэл хамгаалуулагчийг хорих ангид эрхэлж байсан ажил хөдөлмөр, олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй байх;

3.2.5.3.хамгаалуулагчийг байрлуулж буй өрөөнөөс гаргаж, хөдөлгөөн үйлдэх үед бусад хоригдол, хоригдогч, албан хаагчдын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, зөрүүлэх байдлаар аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах;

3.2.5.4.хамгаалуулагчтай өмгөөлөгч, цагдаагийн алба хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, прокурор, шүүгч бусад хүн

уулзах тохиолдолд бие даан шийдвэр гаргахгүй ба хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагад урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 213 дугаар зүйлд зааснаар уулзалтын арга хэмжээг зохион байгуулах;

3.2.5.5. хорих анги, цагдан хорих байранд 3.2.5, 3.2.6-д заасныг хангах бүхий л ажил, арга хэмжээг зохион явуулсан боловч хамгаалалтын арга хэмжээний шаардлагыг хангаагүй эсхүл биелүүлэх боломжгүй тохиолдолд энэ журмын 1.5-д заасныг хэрэгжүүлж ажиллах;

3.2.5.6. хамгаалуулагчид хорих ангийн дотоод журамд заасан зөвшөөрөгдсөн эд зүйлийг хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагын алба хагчийг байлцуулан үзлэг, эд үйлд нэгжлэг хийж оруулах ба бусад хориотой эд зүйлсийг эргэлт, уулзалтаар болон алба хаагчдаар дамжуулан оруулахгүй байх;

3.2.5.7. хамгаалалтын арга хэмжээ авагдсан хамгаалуулагчийн өрөө, байранд прокурорын зөвшөөрөлтэйгээс бусад хүмүүс, хорих ангийн алба хаагчдыг оруулахгүй байх;

3.2.6. нэгдсэн эмнэлэг, хорих ангийн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээнд дараах нөхцөл байдлыг харгалзан ажиллана:

3.2.6.1. хорих анги, цагдан хорих байрны эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээний явцад хамгаалуулагчийг тусгаарлах;

3.2.6.2. хамгаалуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн туслалцаа, эмчилгээнд хамруулах явцад үүссэн баримт бичиг, өвчтөний түүхийг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагад хуулбарлан өгөх;

3.2.6.3. хорих байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн хамгаалуулагчийн эмнэлгийн тусламж авах хүсэлтийн дагуу цаг алдалгүй, эрүүл мэндийн туслалцаа үзүүлж, шаардлагатай оношилгоо, эмчилгээнд хамруулах;

3.2.7. хамгаалуулагчийг хорих байгууллагын нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хорих ангийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа тохиолдолд эрх, үүрэг бүхий эмнэлгийн эмч, ажилтнаас бусад хүмүүсийг зөвхөн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын зөвшөөрлийн дагуу уулзуулах;

3.2.8. хорих байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн хамгаалуулагчийн эрүүл ахуй, хоол хүнсний боловсруулалт, амт чанарт өдөр бүр хяналт тавьж, хоолны дээжийг холбогдох журам, зааврын дагуу хадгалах, устгах;

3.2.9. хамгаалуулагчийг хорих анги, цагдан хорих байранд хүлээн авах, шилжүүлэх, эмнэлгийн тусламж авах зайлшгүй шаардлагын улмаас эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор түр хугацаагаар гарах, ирэх, хамгаалалт хэрэгжиж эхлэх дуусах, суллагдах тохиолдол бүрт тухайн хорих байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн үзлэг /шарх, сорви, гэмтэл, сэтгэц, биеийн жин, өндөр гэх мэт/ хийж, өвчлөлийн талаар асууж, эрүүл мэндийн байдлыг тодорхойлон, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хувийн хэрэгт хавсаргана.

3.3.Хамгаалуулагчийн аюулгүй байдал, эрсдлийн түвшинг тогтоох зорилгоор нийгмийн ажилтан аюулын зэргийн үнэлгээг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж эхлэхийн өмнө авна.

Дөрөв.Хамгаалуулагчийн эрх, үүрэг

4.1.Хамгаалуулагч дор дурсан эрх эдэлнэ:

4.1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу туслалцаа авах;

4.1.2.хамгаалалтын арга хэмжээний талаар санал, хүсэлт гаргах, эрх бүхий албан тушаалтанд уламжлуулж шийдвэрлүүлэх;

4.1.3.хамгаалалтын арга хэмжээний болон өөрийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдах.

4.2.Хамгаалуулагч дор дурсан үүрэг хүлээнэ:

4.2.1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/183 тушаалаар баталсан “Хорих ангийн дотоод журам”, мөн сайдын 2014 оны А/209 дүгээр тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг хорих анги болон цагдан хорих байранд хоригдож байгаа хамгаалуулагч дагаж мөрдөх;

4.2.2.хамгаалалтын арга хэмжээний шаардлага, арга хэмжээ, зөвлөмж, алба хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

4.2.3.хамгаалуулагч өөрт нь ямар нэгэн аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаар мэдсэн даруйд хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагад мэдэгдэх.

Тав. Бусад зүйл

5.1.Хамгаалуулагч нь хорих ангийн дотоод журам, хорих ангийн даргын баталсан цагийн хуваарийг дагаж мөрдөөгүй, уг журамд заасан заалтыг зөрчсөн, түүнчлэн дагаж мөрдөхөөр заасан холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хамгаалалтын арга хэмжээ цуцлагдах үндэслэл болно.

5.2.Хамгаалалтын арга хэмжээний үйл ажиллагааны үр дүнг үндэслэн алба хаагчдыг урамшуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж болно.

5.3.Хамгаалуулагч болон хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч байгууллага, алба хаагч, хүн нь төрийн байгууллага, алба хаагч, хувь хүний нууцад хамаарах мэдээ, мэдээллийг нийтэд задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

5.4.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГАТАЙ АЖИЛЛАХ ГЭРЭЭ

20 ... оны ... сарын ...-ны өдөр № _____ хот,
аймаг

Энэхүү гэрээг нэг талаас Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай алба /цаашид “Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага” гэх/ _____ цолтой _____ нөгөө талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага /цаашид “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” гэх/ _____ цолтой _____ нар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 230 дугаар зүйлийн 230.5 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны _____ тушаалаар баталсан “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-ын 1.3 дахь хэсэг, _____ аймаг, дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч /аль тохирохыг доогуур зурах/ _____-ны 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар тогтоол, захирамж /аль тохирохыг доогуур зурах/-ийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах ажлыг нэг талаас Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай алба, нөгөө талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих анги, цагдан хорих байр хамтран ажиллах, харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтална.

Хоёр.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

2.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн хувийн мэдээ, мэдээллийг цуглуулах, гаргуулан авах;

2.1.2.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

2.1.3.хамгаалуулагчид эргэлт уулзалт, уулзах хүн, оролцох арга хэмжээ, бусад нөхцөл байдлыг тусгасан мэдээлэл бүхий хөдөлгөөний чиглэлийг 24 цагаас доошгүй хугацааны өмнө энэхүү гэрээний хавсралт маягтын дагуу урьдчилж авах;

2.1.4.хамгаалуулагчийг шүүх хурал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд оролцуулах, эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх, чөлөө авч хөдөлгөөн үйлдэх чиглэлээс бусад хөдөлгөөн үйлдэхгүй байхыг хамгаалуулагчаас шаардах;

2.1.5.хөдөлгөөний чиглэлийн дагуу биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд халдах шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд аюулгүй газарт хүргэх ажиллагааг нэн даруй зохион байгуулах;

2.1.6.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хяналт тавих зорилгоор түүний амьдралын бүсэд тусгай техник, хэрэгсэл байршуулан ашиглах;

2.1.7.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хорих анги, цагдан хорих байранд гадны халдлага, бослого, үймээн самуун гарсан, гарч болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд хамгаалуулагчийн хоригдож байгаа амьдралын бүсэд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.2.Тухайн өдрийн нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлгөөний чиглэлийг өөрчлөх, цуцлах саналыг хамгаалуулагч талтай зөвшилцөж болно.

2.3.Хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцана.

2.4.Хамгаалуулагч нь хорих анги болон цагдан хорих байранд хамгаалагч талд урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн хөдөлгөөн үйлдэж гадны халдлага, довтолгоонд өртсөн тохиолдолд хамгаалагч тал хариуцахгүй.

Гурав. Хамтран хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

3.1.Хамтран хэрэгжүүлэх байгууллага нь дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.хамгаалуулагчид хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх шийдвэртэй танилцан хорих анги, цагдан хорих байранд аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг зохион байгуулж, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хамтран ажиллах;

3.1.2.хамгаалалтын явцад хамгаалуулагчтай Хууль зүй, дотоод хэргийн сайдын оны ... тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”, мөн сайдын оны ... дүгээр тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.1.3.хамгаалуулагчийг хорих байранд хүлээн авах, цагдан хорих нэг байрнаас нөгөөд шилжих болон эмнэлгийн тусламж авах зайлшгүй шаардлагын улмаас эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, түүнчлэн эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор түр хугацаагаар гарах, ирэх, хамгаалалт хэрэгжиж эхлэх дуусах, суллагдах тохиолдол бүрт тухайн хорих байрны эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн үзлэг /шарх, сорви, гэмтэл, сэтгэц, биеийн жин, өндөр гэх мэт/ хийж, өвчлөлийн талаар асууж, эрүүл мэндийн байдлыг тодорхойлон, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж, хувийн хэрэгт хавсаргах;

3.1.4.хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын алба хаагчдын албаны нууцлал аюулгүй байдлыг ханган ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.5. хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын гаргасан саналын дагуу хоригдлын өрөөг солих, тусгаарлах, хорих байр хоорондын шилжүүлэх хөдөлгөөн хийх ажлыг эрх бүхий албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх ажлыг зохиох байгуулах;

3.1.6. хамгаалуулагчийг шүүх хуралд оролцуулах, өөр хорих анги, цагдан хорих байранд шилжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаанд оролцуулахаар хорих ангийн бүсээс гарч гадуур хөдөлгөөн үйлдэх тохиолдолд гэрч, хохирогчийг хамгаалах албанд урьдчилан мэдэгдэх, санал солилцож хамтран ажиллах.

3.2. Хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцана.

Дөрөв. Хориглох зүйл

4.1. Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1. талууд хамгаалалтын арга хэмжээний талаарх мэдээллийг бусдад дамжуулах, задруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ярилцлага өгөх;

4.1.2. хамгаалуулагч хамгаалалтын арга хэмжээний үеэр согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэх;

4.1.3. хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа хамгаалуулагчийн амьдралын бүсэд прокурорын зөвшөөрөлтэйгээс бусад хүмүүс, хорих ангийн алба хаагч, ажилтныг оруулах;

4.1.4. хувийн харилцаа тогтоох.

Тав. Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

5.1. Хамгаалалтын арга хэмжээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан үндэслэлээр цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтад заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний хавсралт

7.1. Хамгаалуулагчийн явах чиглэл, оролцох арга хэмжээний талаар холбогдох маягтын дагуу бичгээр өгнө. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм. Бусад нөхцөл

8.1.Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.

8.2.Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.

8.3.Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалалтын арга хэмжээг
хэрэгжүүлэх байгууллагыг төлөөлж:

Хамтран хэрэгжүүлэх
байгууллагыг төлөөлж:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

**ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

20 оны дүгээр сарын -ны өдөр № _____ хот,
аймаг

Энэхүү гэрээг нэг талаас хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага _____ цолтой _____, нөгөө талаас _____ регистрийн дугаартай _____ овогт _____ -ын _____ /цаашид “хамгаалуулагч” гэх/ нар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 7, 17, 18, 20-24 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны _____ тушаалаар баталсан “Цагдан хоригдож байгаа болон хорих ангид ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-ын 1.3 дахь хэсэг, _____ аймаг, дүүргийн прокурор, эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч /аль тохирохыг доогуур зурах/ _____-ны 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар тогтоол, захирамж/ аль тохирохыг доогуур зурах/-ийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалалтын арга хэмжээг эрсдэлгүй, хэвийн зохион байгуулахад гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтална.

Хоёр. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

2.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

2.1.2.хөдөлгөөн үйлдэх чиглэлийн дагуу биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд халдах шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд аюулгүй газарт хүргэх ажиллагааг нэн даруй зохион байгуулах;

2.1.3.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хяналт тавих зорилгоор түүний амьдралын бүсэд тусгай техник, хэрэгсэл байршуулан ашиглах;

2.1.4.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хорих анги, цагдан хорих байранд гадны халдлага, бослого, үймээн самуун гарсан, гарч болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд хамгаалуулагчийн хоригдож байгаа амьдралын бүсэд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.1.5.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах;

2.1.6.хамгаалуулагч нь хорих анги болон цагдан хорих байранд хамгаалагч талд урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн хөдөлгөөн үйлдэж гадны халдлага, довтолгоонд өртсөн тохиолдолд хамгаалагч тал хариуцахгүй.

Гурав. Хамгаалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хамгаалуулагч нь дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.хамгаалалтын арга хэмжээний талаар санал, хүсэлт гаргах, эрх бүхий албан тушаалтанд уламжлуулж шийдвэрлүүлэх;

3.1.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан туслалцаа авах;

3.1.3.хамгаалалтын арга хэмжээний болон өөрийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдах.

3.1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, хамгаалагч талаас өгсөн заавар, зөвлөмжтэй танилцаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.1.5.хамгаалагч талд гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, найз нөхөд, бусад шаардлагатай мэдээллийг саадгүй гаргаж өгөх;

3.1.6.хорих анги, цагдан хорих байрны дотоод журам, цагийн хуваарийг дагаж, мөрдөх;

3.1.7.хамгаалагч талаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

3.1.8.хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;

3.1.9.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хамгаалах, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах;

3.1.10.хамгаалуулагч нь хорих анги, цагдан хорих байранд хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтанд урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн хөдөлгөөн үйлдэхгүй байх.

Дөрөв. Хориглох зүйл

4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын оны тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”, мөн сайдын оны дүгээр тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг зөрчих;

4.1.2.хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа алба хаагч нь хамгаалуулагчтай хувийн харилцаа тогтоохгүй байх;

4.1.3.хамгаалуулагч нь хорих ангийн даргын баталсан цагийн хуваарийг зөрчих, хөдөлгөөн үйлдэх;

4.1.4. хамгаалуулагч нь хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын алба хаагч болон хорих анги, цагдан хорих байрны алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсхүл алба хаагчидтай зүй бус харьцах;

Тав. Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

5.1. Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь хэсэгт заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зураа. Маргаан шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний хавсралт

7.1. Хамгаалуулагч нь явах чиглэл, оролцох арга хэмжээний талаар холбогдох маягтын дагуу бичгээр өгнө. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм. Бусад нөхцөл

8.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.

8.2. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.

8.3. Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:

Хамгаалуулагч:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

**НАСАНД ХҮРЭЭГҮЙ ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

20 ... оны ... дүгээр сарын ...-ны өдөр № _____ хот,
аймаг

Энэхүү гэрээг нэг талаас хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага
_____ цолтой _____ нөгөө
талаас _____ регистрийн дугаартай _____ овогт
_____ -ны _____ /цаашид “хамгаалуулагч” гэх/
төлөөлж _____ албан тушаалтай
_____ нар Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 5, 7, 17, 18, 20-
24 дүгээр зүйл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны _____ тушаалаар
баталсан “Цагдан хоригдож байгаа болон хорих ангид ял эдэлж байгаа гэрч,
хохирогчийг хамгаалах журам”-ын 1.3 дахь хэсэг, _____ аймаг, дүүргийн
прокурор, эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч /аль тохирохыг доогуур
зурах/ _____ -ны 20... оны ... сарын ...-ны өдрийн дугаар тогтоол,
захирамж/ аль тохирохыг доогуур зурах/-ийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн хамгаалуулагчийн амь бие, эрүүл мэндийг гадны халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалалтын арга хэмжээг эрсдэлгүй, хэвийн зохион байгуулахад гэрээний зорилго оршино.

1.2.Талууд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтална.

Хоёр. Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын эрх, үүрэг

2.1.Хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.хамгаалуулагчид аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой чиглэлээр заавар, зөвлөмж өгөх, шаардлага тавих, баталгаа гаргуулан авах;

2.1.2.хөдөлгөөн үйлдэх чиглэлийн дагуу биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байх явцад хамгаалуулагчийн амь нас, эрүүл мэндэд халдах шинэ нөхцөл байдал илэрсэн тохиолдолд аюулгүй газарт хүргэх ажиллагааг нэн даруй зохион байгуулах;

2.1.3.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хяналт тавих зорилгоор түүний амьдралын бүсэд тусгай техник, хэрэгсэл байршуулан ашиглах;

2.1.4.аюулын эрсдэлийн түвшин нэмэгдсэн, түүнчлэн хорих анги, цагдан хорих байранд гадны халдлага, бослого, үймээн самуун гарсан, гарч болзошгүй нь тогтоогдсон тохиолдолд хамгаалуулагчийн хоригдож байгаа амьдралын бүсэд аюулгүй ажиллагааны урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.1.5.хамгаалуулагчийн хууль ёсны шаардлагыг хүлээн авч, түүнтэй хүндэтгэлтэй, зөв боловсон, хуулийн хүрээнд харьцах;

2.1.6.хамгаалуулагч нь хорих анги болон цагдан хорих байранд хамгаалагч талд урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн хөдөлгөөн үйлдэж гадны халдлага, довтолгоонд өртсөн тохиолдолд хамгаалагч тал хариуцахгүй;

2.1.7.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан туслалцааг хамгаалуулагчийн хүсэлтийн дагуу үзүүлэх.

Гурав. Хамгаалуулагчийн эрх, үүрэг

3.1.Хамгаалуулагч нь дараах эрх, үүрэгтэй:

3.1.1.хамгаалалтын арга хэмжээний талаар санал, хүсэлт гаргах, эрх бүхий албан тушаалтанд уламжлуулж шийдвэрлүүлэх;

3.1.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан туслалцааг авах;

3.1.3.хамгаалалтын арга хэмжээний болон өөрийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдах.

3.1.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, хамгаалагч талаас өгсөн заавар, зөвлөмжтэй танилцаж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3.1.5.хамгаалагч талд гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, найз нөхөд, бусад шаардлагатай мэдээллийг саадгүй гаргаж өгөх;

3.1.6.хорих анги, цагдан хорих байрны дотоод журам, цагийн хуваарийг дагаж, мөрдөх;

3.1.7.хамгаалагч талаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

3.1.8.хамгаалагч талд хаанаас, ямар аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээллийг гаргаж өгөх, цаашид нөхцөл байдлыг тухай бүр мэдэгдэх;

3.1.9.хамгаалуулагч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээд, өмгөөлөгч нь хамгаалалтын арга хэмжээний талаарх нууцлалыг хамгаалах, бусдад задруулахгүй байх, баталгаа гаргах;

3.1.10.хамгаалуулагч нь хорих анги, цагдан хорих байранд хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа эрх бүхий албан тушаалтанд урьдчилан мэдэгдэхгүйгээр дур мэдэн хөдөлгөөн үйлдэхгүй байх.

Дөрөв. Хориглох зүйл

4.1.Талууд дараах нөхцөл байдал үүсгэх, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

4.1.1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын оны тушаалаар батлагдсан “Хорих ангийн дотоод журам”, мөн сайдын оны дүгээр тушаалаар баталсан “Хорих байрны дотоод журам”-ыг зөрчих;

4.1.2.хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа алба хаагч нь хамгаалуулагчтай хувийн харилцаа тогтоохгүй байх;

4.1.3.хамгаалуулагч нь хорих ангийн даргын баталсан цагийн хуваарийг зөрчих, хөдөлгөөн үйлдэх;

4.1.4. хамгаалуулагч нь хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагын алба хаагч болон хорих анги, цагдан хорих байрны алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсхүл алба хаагчидтай зүй бус харьцах;

Тав. Гэрээний хугацаа, түүнийг дуусгавар болгох

5.1. Хамгаалалтын арга хэмжээг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр цуцлах хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

5.2. Хамгаалуулагч нь хамгаалагч талаас өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын заавар, зөвлөмж, хууль, журам болон энэхүү гэрээг 2 буюу түүнээс дээш удаа санаатайгаар зөрчсөн тохиолдолд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь хэсэгт заасныг үндэслэн цуцлуулах саналаа мөн хуулийн 20.2.2-т заасан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, цуцлуулна.

Зураа. Маргаан шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан, түүнчлэн уг гэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний хавсралт

7.1. Хамгаалуулагч нь явах чиглэл, оролцох арга хэмжээний талаар холбогдох маягтын дагуу бичгээр өгнө. Энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Найм. Бусад нөхцөл

8.1. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй болно.

8.2. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр үйлчилж, гэрээнд заасан хугацаанд үйлчилнэ.

8.3. Энэхүү гэрээгээр шууд зохицуулаагүй аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Гэрээ байгуулсан:

Хамгаалагч талыг төлөөлж:

Насанд хүрээгүй хамгаалуулагч талыг төлөөлөгч

